



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/241

Чингис хот

Дэд бүтцийн ажлын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.4-ын "а", "б", "в", "г", "д", 29.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд дэд бүтцийн ажлуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах замаар үндэслэлтэй, шуурхай шийдвэр гаргах, зорилго бүхий Дэд бүтцийн ажлын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|-----------------------|---|
| Зөвлөлийн дарга: | Аймгийн Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга: | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Аймгийн Засаг даргын орлогч Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга ГХБХБГ-ын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Орон нутгийн өмчийн газрын дарга Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын захирал Хэнтий-Ус ХХК-ийн захирал Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн Хэнтий аймаг дахь газрын дарга |


2. Дэд бүтцийн ажлын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/17 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА



ДЭД БҮТЦИЙН АЖЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Аймгийн хэмжээнд дэд бүтцийн ажлуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах замаар үндэслэлтэй, шуурхай шийдвэр гаргахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагаа

- 2.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.
- 2.2. Хурлаар дэд бүтцийн ажлуудын төлөвлөлт, хэрэгжилтийн явц болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, харилцан мэдээлэл солилцох, дэд бүтцийн холбогдолтой бусад асуудлыг хэлэлцэнэ.
- 2.3. Хурлын үйл ажиллагааны бэлтгэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хангах бөгөөд хуралдааныг зөвлөлийн дарга удирдан явуулна.
- 2.4. Зөвлөлийн гишүүд хэлэлцэх асуудалтай нарийн танилцаж, санал дүгнэлт гарган хуралдаанд идэвхтэй оролцох үүрэгтэй.
- 2.5. Зөвлөлийн гишүүд хуралд оролцох боломжгүй тохиолдолд зөвлөлийн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй бөгөөд өөрийн албан үүргийг орлох албан тушаалтныг оролцуулна.
- 2.6. Зөвлөлийн дарга хэлэлцэх асуудлын онцлог, хамрах хүрээг харгалзан зөвлөлийн гишүүдээс гадна төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн удирдлага, холбогдох албан хаагчийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр хурлыг хуралдуулж болно.

Гурав. Зөвлөлийн хурлын тэмдэглэл

- 3.1. Зөвлөлийн хурлаас тэмдэглэл гарах бөгөөд тэмдэглэлийг Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн хөтөлж, тэмдэглэлд тусгагдсан асуудлыг холбогдох албан тушаалтан, байгууллага, иргэдэд хүргүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хариуцна.
- 3.2. Тэмдэглэлд тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, зөвлөлийн гишүүдийн ирцийн байдал, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой холбогдон гарсан асуулт, хариулт, санал дүгнэлт, эцсийн шийдвэрийг тодорхой бичнэ.